



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/ЗНН

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авто замын сангийн хөрөнгө оруулалт, Булган сумын төсвийн хөрөнгө оруулалтаас хэрэгжих “Зүүн түрүүний голын төмөр бетон гүүр 45,8 у/м (Булган сум)” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Цэнгийн зам” ХХК-тай 1,578,516,690 (нэг тэрбум таван зуун далан найман сая таван зуун арван зургаан мянга зургаан зуун ер) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т, тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т тус тус үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Цэнгийн зам” ХХК-ийн захирал (М.Батдорж)-д даалгасугай.

4.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.


5.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Авто замын сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (О.Сайнзаяа), Булган сумын төсвийн хөрөнгө хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Н.Мөнхжаргал)-д тус тус зөвшөөрсүгэй..

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 08-ны/ний өдрийн
...А/В/С/ дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт




Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	27'795'134	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	21'989'175	Ү.Бямбасүрэн
3	Нормчлолын сан	5,559,027	Ү.Бямбасүрэн
4	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	О.Сайнзаяа Н.Мөнхжаргал
5	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	О.Сайнзаяа Н.Мөнхжаргал Ү.Бямбасүрэн
6	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	О.Сайнзаяа Н.Мөнхжаргал
7	Ажил гүйцэтгэх хугацаа	2026.05.06-2026.10.31 2027.04.01-2027.09.30	Ү.Бямбасүрэн

--o0o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 08-ны/ний өдрийн
А/ЗЧ дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн
ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Ерөнхий инженер	Ц.Цэрэнсамбуу	Ү.Бямбасүрэн
2	Авто замын инженер	Ё.Энхбат	
3	Гүүрийн инженер	Б.Энхбат	
4	Материалын инженер	С.Саранхүү	
5	Геодезийн инженер	Э.Галхүү	
6	ХАБЭА-н ажилтан	Д.Батсайхан	
Машин механизмын жагсаалт			Ү.Бямбасүрэн
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар	
1	Экскаватор 1м3	3121 ММВ	
2	Автокран 16 тонн	4798 УВС	
3	Ачааны автомашин 10 тонн	5121 УВВ	
4	Ачааны автомашин 5 тонн	5099 УВС	
5	Ковш	3123 ММВ	
6	Индүү	3122 ММВ	

--o00o--